



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/41

Баян-Овоо сум

Э.Уранбайгалийг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, (Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ)-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэбатын Уранбайгалийн жирэмсний болон амаржсаны амралт дуусгавар болсон тул өөрийн хүсэлтийг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бага ангийн багшийн үүрэгт ажилд томилсугай.

2. Э.Уранбайгалийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Энхболор

Бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч

Гишүүд: П.Болортунгалаг

Бага ангийн багш

Т.Хэрлэнчимэг

Аж ахуйн нярав

3. Э.Уранбайгалийн сарын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэлээр тогтоон 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувь, анги даасны нэмэгдэл 10 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, заах аргач мэргэжлийн зэргийн нэмэгдэл 10 хувиар зохих хууль журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д, ажил үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сургалтын менежер (П.Болортуяа)-д тус тус үүрэг болгосугай.

4. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Э.Уранбайгальд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА

